

Рубрик

Өмнө дурьдсанчлан рубрик нь оюутны хийсэн зүйл болон түүнд тохирох чанарын түвшингүүдийг харьцуулан харуулсан үнэлгээний хэрэгсэл юм. Рубрик нь уян хатан бөгөөд суралцахуйн ямар ч үр дүнгүүд(илтгэл, эссе, лабораторийн ажил, бүлгээр хийх ажил, портфолио г.м.)-д тохирдог.

Чанарыг шалгах ажил нь хэд хэдэн хүчин зүйлсээс тогтох үед рубрик нь маш сайн тохирдог. Рубрик нь эссе болон тайлангийн агуулга, зохиомж аль алиныг үнэлж чадна.

Рубрик нь дараах боложийг олгоно:

- Үнэлгээнд нөлөөлөх гадны хүчин зүйлийг бууруулах. Үнэлэх шалгуурыг тодорхой зааж өгдөгөөрөө бодитой байх нөхцлийг ихэсгэдэг.
- Олон үнэлэгчийн үнэлгээг нийцтэй байх боломжыг ихэсгэнэ. Ажлын хэсэг, бүлгээр үнэлж байх үед маш чухал байдаг.
- Олон төрлийн нотолгоог нэг зэрэг үнэлдэг.
- Суралцагчдад хөтөлбөрийн үр дүнд хэрхэн хүрэх талаар мэдээлэл болно.

Рубрикийг гурван элементээр зохиодог: доод, дунд дээд чанарыг ялгах түвшин, түвшин болгоныг ялган тодорхойлох шинжүүр, эсвэл шинжүүрүүд, мөн түвшин бүрийг тодорхойлсон дескрипторууд.

Рубрикийг хэрхэн зохиох вэ?

Рубрикийг зохиох таван алхам байдаг:

1-р алхам. Гүйцэтгэлийн зорилго буюу үр дүнг тодорхойлох

Гүйцэтгэлийн зорилго буюу үр дүн нь суралцагч, оюутан нь хичээлийн үр дүнд эзэмших ёстой **тусгай** мэдлэг, ур чадвар, хандлага(компетенц) зэргийг заасан өгүүлбэр юм.

2-р алхам. Гүйцэтгэлийг харуулах хэмжээс/тасгийг тодорхойлох

Хэмжээс гэдэг оюутнууд үйл ажиллагааг гүйцэтгэж байх үед хийх тусгай даалгавар таскуудын өргөн ойлголт юм.

Хэмжээс нь тусгай даалгавар байж болно эсвэл нэг эсвэл олон сэдвийг хамарсан оюуны болон танин мэдэхүйн компетенцүүдэд хандсан байж болно.

Жишээлбэл тусгай кейс буюу тохиолдлыг бүлгээрээ судлаж анализ хийж байх үеийн хэмжээсийн жишээ нь дараах байж болно:

- Бүлгийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах
- Шаардлагатай ажилд хариуцлага хүлээх
- Бусдын үзэл бодлыг үнэлж үзэх
- Судалгаанд хамтдаа анализ хийх
- Үр дүнг өгсөн форматын дагуу танилцуулах

3-р алхам. Чанарын боломжит түвшингүүдийг тодорхойлох

Түвшингүүд нь хамгийн муугаас хамгийн сайн хүртлэх чанарын түвшингүүдийг тодорхойлно.

Гурван түвшний жишээ: муу, дунд, сайн

Дөрвөн түвшний жишээ: эхлэл, хөгжиж буй, эзэмшсэн, үлгэр жишээ

Таван түвшний жишээ: муу, дундаас доогуур, дунд, сайн, онц сайн

4-р алхам. Түвшин болгонд тоон утга харгалзуулж, үнэлгээний нийт оноог тодорхойлох

Хэрэв бид 5 түвшинтэй байгаа бол таван хэмжээстэй ба манай нийт оноо 25 болно.(түвшинд харгалзан 1,2,3,4,5 оноо өгнө гэж үзвэл, 5 хэмжээс х 5 оноо.)

5-р алхам. Чанарын түвшин болгоны шинжүүрийг тодорхойл

Хэмжээс болгоны хамгийн сайн чанараас эхэлнэ. Энгийнээр хэлбэр оюутнаас хүлээж болох тодорхой зүйлсийг жагсаа. Тэгсний дараа хамгийн сайн чанараас дооших бүх түвшний хувьд хамгийн дээд түвшингийнхээс бага оноо өгөх нөхцлийг хангах дутагдалтай элементүүдийг тодорхойлно.

Зөвлөгөө: Шалгуурыг жагсааж байхдаа сөрөг хэллэг ашиглахаас зайлсхий. Үүний оронд дутуу байгаа шинжүүрийг тодорхойлох гэж хичээгээрэй, ингэснээр оюутан тэд яагаад доогуур үнэлгээ авснаа мэдэх болно.

Рубрикийг гурван төрөл:

- Analytic Rubrics/Аналитик рубрик
- Developmental Rubrics/Хөгжлийн рубрик
- Holistic Rubrics/Нэгдмэл рубрик

Бид аналитик болон нэгдмэл рубрикийн талаар авч үзэх болно:

1. Аналитик рубрик:

Аналитик рубрик нь хүснэгтийн зүүн багананд оюутны гүйцэтгэл, гүйцэтгэлийн түвшинг тодорхойлсон дээд мөрний харалдаа харгалзах гүйцэтгэлийг бичдэг.

Бичгийн ажлын аналитик рубрикийн жишээ – Төгсгөлийн шалгалт: (Дээд оноо =4 шалгуур x 4 оноо =16)

| Оюутны ажлын шалгуур | Маш сайн (4) | Сайн (3) | Дунд(2) | Муу (1) |
|---|--|--|--|---|
| Тодорхий байдал (агуулгыг харгалзах мэдээлэл, үзэл санаагаар дэмжсэн) | Хийсэн зүйлийн зорилго тодорхой, дэмжиж буй үзэл санаа нь маш сайн төвлөрсөн. Жижиг деталиуд нь маш хамааралтай. | Хийсэн зүйлийн зорилго тодорхой, дэмжиж буй үзэл санаа нь бараг ихэнхдээ төвлөрсөн. Зарим нэг деталийг оруулсан. | Хийсэн зүйлийн гол зорилгыг сайжруулах шаардлагатай. Зарим деталиуд орхигдсон. | Зорилго тодорхойлогдоог бодлууд холбогд |

| Оюутны ажлын шалгуур | Маш сайн (4) | Сайн (3) | Дунд(2) | Муу (1) |
|---|---|---|--|---|
| Зохион байгуулалт (элемент, үзэл санааны дараалал) | Мэдээлэл болон үзэл санаа нь логик дараалалд орж нэг нэгнээсээ урсан гарсан. Мөн уншигчид хүрсэн. | Мэдээлэл болон үзэл санаа нь логик дарааллын хувьд уншигчид бага зэрэг эсвэл хүндрэлгүйгээр хүрсэн. | Мэдээлэл болон үзэл санаа нь логик дарааллыг уншигч хамгийн бага хүндрэлтэйгээр дагаж чадна. | Мэдээлэл болон санааны дараалал Уншигч бодлын у холбоог дагахад хүндрэлтэй. |
| Илтгэж, үзүүлсэн байдал (дүрэм болон зөв бичлэгийн алдаагүй байдал) | Дүрэм болон зөв бичлэгийн алдаагүй, уншихад хялбар. | Зөв бичлэгийн цөөн алдаатай(1-2 алдаа) эсвэл дүрмийн цөөн алдаатай энэ нь уншихад нөлөө багатай | Зөв бичлэгийн зарим алдаатай(2-3 алдаа) эсвэл дүрмийн алдаануудтай гэхдээ энэ нь уншигчийн анхаарлыг бичсэн зүйлсээс сарниулдаг. | Зөв бичлэгийн ол алдаатай(5+ алд эсвэл дүрмийн ол алдаатай энэ нь зүйлийг уншихад төвөгтэй болгодог |
| Оригинал болон шинэлэг байдал (өөрийн гэсэн хувь нэмэр оруулсан) | Өөрийн гэсэн өвөрмөц санааг оруулсан шинэлэг санаа, саналуудтай. | Үнэтэй үзэл санаа, шинэлэг санаатай. | Зарим нэг үнэлж болохуйц шинэ санаатай. | Шинэ, шинэлэг санаа байхгүй. |

2. Нэгдмэл рубрик

Нэгдмэл рубрик нь үнэлгээнд авч хэрэглэж байгаа бүх шалгуур(ж.нь. тодорхой байдал, зохион байгуулалт, илтгэж танилцуулсан байдал, шинэлэг байдал г.м.)-ыг нэг хэмжүүртэйгээр авч үздэг. Нэгдмэл рубрикийн хувьд оюутны нийт хийсэн ажлыг бүхэлд нь авч үзэж 1-с 4 хүртэл нэг л оноо өгнө. Үнэлгээ өгөгч нь оюутны хийсэн зүйлийг хэмжүүр дээрх нэг утганд харгалзуулна.

Нэгдмэл рубрикийн жишээ

Бичгийн ажлын жишээн дээ - төгсөлтийн ажил /төсөлт ажил

1. Муу: Оюутны хийсэн ажлын зорилго эсвэл гол санааг уншигч тодорхой эсвэл хялбархан тодорхойлж чадахгүй. Зохион байгуулалтгүй өгсөн мэдээллээс уншигч зохиогчийн санааг ойлгоход хүндрэл учирдаг. Зөв бичгийн хувьд олон алдаатай мөн механик олон алдаа байгаа нь уншигчийг төвлөрөхөд саад болж байна.
2. Хангалттай: Уншигч оюутны хийсэн ажлын зорилгыг хүндрэлгүй ойлгож дэмжиж хүч оруулж буй санаануудтай тэдгээр нь тодорхой. Үзэл санааны холбоосыг нь дагахад хүндрэл багатай. Зөв бичих дүрмийн болон механик алдаа цөөн хэд байгаа хэдий ч тэр нь ажлаас анхаарал хүчтэй сарниулахгүй.
3. Сайн: Уншигч нь оюутны ажлын гол санааг хялбархан ойлгох ба гол санааг дэмжиж, хүч оруулсан хэсгүүдтэй. Мэдээллийг логикийн зөв дараалалтай учир уншихад ойлгомжтой. Зөв бичгийн алдаа болон механик алдаанаас үүдэлтэй анхаарал сарнил багатай.
4. Маш сайн: Уншигч ажлын гол асуудлыг хялбархан ойлгож тодорхой санаа болон оновчтой жижиг деталиудын тусламжтайгаар ажилд татагдан ордог. Мэдээллийг логик зөв дараалалтай танилцуулсан.

ОЮУТНЫ ҮНЭЛГЭЭ БА ДҮН

Оюутны сурлагын үнэлгээтэй холбоотой хэд хэдэн **зарчим** байдаг. Шилдэг туршлагаудаас авсан 9 зарчмыг дор жагсаав. Оюутны сурлагын үнэлгээ:

- Сургуулийн үнэт зүйлсээс эхэлнэ;
- Суралцах үйл ажиллагаа нь олон хэмжээст, интеграцлагдсан, хугацааны явцад гүйцэтгэлээр илэрч гардаг гэдгийг ойлгосон үед илүү үр дүнтэй.;
- Сайжруулахаар зорьж буй хөтөлбөр нь тодорхой заасан зорилготой үед хамгийн сайн ажилладаг;
- Суралцахуйн үр дүнд анхаарал шаарддагийн зэрэгцээ тэдгээр үр дүн рүү хөтлөдөг үйл ажиллагаа руу анхаарал бас шаарддаг;
- Тохиолдлын чанартай биш үргэлжилсэн шинж чанартай бол хамгийн сайн үр дүнтэй;
- Боловсролын хүрээллийн өргөн төлөөллийг оролцсон тохиолдолд өргөн хэмжээгээр сайжирдаг;
- Хэрэглэж буй асуудлаас эхлэн хүмүүсийн жинхэнэ анхаарч буй асуулт руу хөтөлбөл илүү их ялгаралыг бий болгоно;
- Өөрчлөлтийг дэмжсэн том нөхцөл байдлын нэг хэсэг болсон тохиолдолд сайжралт авч ирнэ.
- Системийг хариуцлагатай, найдвартай болгоно.

Оюутны үнэлгээтэй хамааралтай үндсэн **асуултууд**:

 Танай сургууль том зорилго тавьсан уу?

Сургууль нь суралцахуйн үр дүнг тодорхойлсон ба амжилтын түвшинг хөндлөнгийн бенчмарктай харьцуулж үнэлдэг. Хөтөлбөр, каррикулумыг байнга үнэлж, дүгнэдэг.

 Танай сургууль оюутны сурлагын талаар нотолгоо цуглуулж байгаа юу?

Суралцахуйн үр дүнг хэзээ, хэрхэн, ямар давтамжтай үнэлэх талаар тусгасан журам, дүрэм үйлчилж хэрэгждэг. Үнэлгээний үйл явц нь үргэлжилсэн,

тогтвортой, багш болон удирдлагууд, ажиллагчдын ажил, даалгавартай интеграцчилагдсан.

🌈 Оюутны сурлагыг нэмэгдүүлэхэд танай сургууль нотолгоог ашигладаг уу?

Оюутны сурлагыг нэмэгдүүлэхэд нотолгоог ашигладаг. Оюутны сурлагыг сайжруулах зорилгоор өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлдэг үйл ажиллагаа хэрэгждэг.

🌈 Танай сургууль нотолгоо, үр дүнг тайлагнадаг уу?

Оюутны сурлагын үр дүнгийн талаарх тайлан нь холбогдох талуудад хүртээмжтэй ба хөтөлбөр, каррикуумыг сайжруулах болон өөрчлөхөд нөлөө үзүүлдэг.

Оюутны үнэлгээний системийн талаарх итгэл үнэмшлүүд

- Үнэлгээний үндсэн зорилго нь оюутны сурлагыг сайжруулах юм (үүнийг төсөлт ажил, даалгавар, тест, эссе, ажиглалт, ярилцлага, туршилт, портфолио зэрэг бүтэцлэгдсэн, албан болон албан бус аргаар хийдэг);
- Өөр зорилгоор хийсэн үнэлгээ нь оюутны сурлагыг дэмждэг (хариуцлага, найдвартай байдлын талаарх мэдээлэл, боловсролын системийн мониторинг);
- Үнэлгээний систем нь бүх оюутны хувьд шударга (үнэлгээний хэрэгсэл, бодлого болон үйл явц нь оюутныг шударга тэгш шалгаж, хүйс болон өөр байдал зэргээс хамаарсан гадны нөлөөгүй);
- Мэргэжлийн хамтын ажиллагаа болон мэргэжил дээшлүүлэлт нь үнэлгээг дэмждэг (сургууль нь багш нараа үнэлгээ, дүгнэх ажилд илүү чадварлаг болоход нь мэргэжлийг дээшлүүлэх замаар дэмжлэг үзүүлэх шаардлагатай);
- Үнэлгээний ажлын хөгжилд өргөн бүрэлдэхүүнтэй оролцох (үнэлгээний зорилго болон арга зүйн талаарх хэлэлцүүлэгт Дээд боловсролын системийг сонирхож буй өргөн хэмжээний хүмүүсийг оролцуулах);

- Үнэлгээний талаар таницуулга, харилцаа холбоо нь тогтмол бөгөөд тодорхой байх (боловсролын ажилтнууд болон сургуулиуд үнэлгээний зорилго, арга зүй, үр дүнгийн талаар нийтэд мэдээлдэг);
- Үнэлгээний системийг тогтмол үнэлж сайжруулах (үнэлгээний систем нь өөрчлөгдөж буй нөхцөл байдал болон мэдлэгийн өсөлтөд нийцэж өөрчлөгдөх ёстой).

ДҮГНЭХ СИСТЕМ

Оюутны хийсэн зүйл болон шалгалтын үр дүнг дүгнэх систем болон оноожуулах систем нь улсуудын хувьд бие биенээсээ байдаг. Зарим улс үндэсний хэмжээний дүнгийн системтэй бол зарим улс тухайн сургууль өөрсдийн системтэй байх боломж олгодог.

Дээд боловсролд хэрэглэгддэг зарим системтэй танилцацгаая:

Нормд суурилсан дүгнэх систем(Norm-Referenced Grading System):

Үнэлгээний систем нь дүгнэж буй оюутнуудын нийт хувьд харгалзах, өмнөөс тодорхойлсон томъёонд суурилсан байдаг. Жишээ нь багш нийт оюутнуудын хамгийн сайн 10% нь онц гэсэн үнэлгээ авна гэж тодорхойлж болно. 100 оюутантай ангийн 10 нь дээд ангилалд орно гэсэн үг.

| | |
|------------------|-------------------------|
| A (онц) | = Ангийн дээд 10 % |
| B (сайн) | = Ангийн дараагийн 20 % |
| C (дундаж) | = Ангийн дараагийн 30 % |
| D (Муу, тэнцсэн) | =дараагийн 20 % |
| F (унасан) | =ангийн доод 20 % |

Нормд суурилсан систем нь боломжит ажлын байр, мэргэжил зэрэг хязгаарлалт тавьсан тохиолдолд оюутан сонгоход ашиглагддаг. Хууль, анагаах ухаан гэх мэт өрсөлдөөн ихтэй салбар болон бэлтгэл хөтөлбөрүүдийн хувьд энэхүү системийг ашиглан анги дүүргэлтийг багасгаж болно.

Шинжүүрт суурилсан үнэлгээний систем:

Шинжүүрт суурилсан дүгнэх систем нь багшийн зүгээс оюутны гүйцэтгэлд үндэслэн ихэвчлэн үсгэн тэмдэглэгээ ашиглан тогтсон хэмжүүрээр үнэлгээ өгдөг систем юм. хэмжүүр нь оюутны чанар, чадвараас хамаарахгүй.

Шинжүүрт суурилсан систем нь дараах хэлбэртэй байж болно:

A= Онц= 95-100=Оюутан хичээлийн сургалтын үр дүнгийн шаардлага, хүлээлтээс давж гарсан. Оюутан агуулгын талаар бүрэн бөгөөд системтэй ойлголттойгоо харуулж, харгалзах ур чадвар болон оюуны түвшинг өндөр хэмжээнд хөгжүүлсэн.

B= Сайн = 85-94= Оюутан хичээлийн сургалтын үр дүнгийн шаардлага, хүлээлтэд өндөр амжилттайгаар тэнцсэн. Оюутан агуулгыг өндөр түвшинд ойлгосоноо харуулсан ба харгалзах ур чадвар болон оюуны түвшинг өндөр хэмжээнд хөгжүүлсэн.

C=Дунд= 75-84= Оюутан хичээлийн сургалтын үр дүнгийн шаардлага, хүлээлтэд амжилттай тэнцсэн. Оюутан нь хичээлийн агуулгын ихэнх хэсгийг сайн ойлгосон ба харгалзах ур чадварыг хангалттай түвшинд эзэмшсэн.

D=Муу=65-74= Оюутан хичээлийн сургалтын үр дүнгийн шаардлага, хүлээлтэд тэнцсэн. Оюутан нь хичээлийн агуулгын үндсэн хэсгийг ойлгосон ба харгалзах ур чадварыг эзэмшсэн.

F (унасан)= -65= Оюутан хичээлийн суралцахуйн үр дүнгийн шаардлагыг хангаагүй.

Тэнцсэн-унасан систем:

Зарим сургууль тэнцсэн-унасан системийг оюутны ажлын үнэлгээ нь хажуугийн нөлөө ихтэй сэдэв эсвэл дадлагын үнэлгээнд хэрэглэдэг. Энэ тохиолдолд оюутны гүйцэтгэлийг үнэлэх рубрик зохиох нь зүйтэй.